



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/204

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 45 дугаар тогтоолоор батлагдсан "Коронавируст халдвар (ковид-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын хэрэгжилтийг хангах, иргэдийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор Баянхутаг сумын "Жаргалант" багт байрлах хяналт, шинжилгээний постыг энэ оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл сунгасан т/л 23 хоногийн хугацаанд ажиллах 7 алба хаагчийн хоол, автомашины шатах тослох материал болон Хэрлэн сумын 4 дүгээр багт байрлах "Хөвчийн жонон", "Эрдэнэ" зэрэг газарт байрлах "Тусгаарлах байр"-нд үүрэг гүйцэтгэж буй 6 алба хаагчийн 7 хоногийн хослны зардлыг нэгдүгээр, аймгийн "Шуурхай штаб"-т энэ оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэл 17 хоног үүрэг гүйцэтгэх 5 алба хаагчийн хоолны зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх, халдварын тархалтын түвшинг тогтооход шаардагдах 6,811,500 (зургаан сая найман зуун арван нэгэн мянга таван зуу) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011299

Зардлын тооцоо

Д/д	Байгууллагын нэр	Шатахууны зардал	Бичиг хэргийн зардал	Хоолны зардал	Тусгаарлах байрны хоолны зардал	Дүн
	Цагдаагийн газар	387,500			840,000	1,227,500
	Онцгой байдлын газар		204,000	3,680,000		3,884,000
	Нийт	387,500	204,000	3,680,000	840,000	5,111,500

05 Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын ... өдрийн А/204
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

Байгууллагын нэр	Дүн
Онцгой байдлын газар /Шуурхай штаб/	1700,000
Дүн	1700,000